



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 29 өдөр

Дугаар A/73

Ховд

Г Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай Г

Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2007 оны “Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай” 330/108 дугаар хамтарсан тушаал, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 224, 288 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал, бүртгэлийн мэргэжилтэн С.Мөнх-Очир нарт Санхүүгийн зохицуулах хорооны орон нутаг дахь төлөөлөгчийн ажил хавсран гүйцэтгүүлсэний нэмэгдлийг сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тооцож олгохоор тогтоосугай.

2. Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдалд 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс, бүртгэлийн мэргэжилтэн С.Мөнх-Очирт 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн тус тус тооцож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

3. Санхүүгийн зохицуулах хорооны хавсран гүйцэтгэж буй ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэн удирдамжаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр хангаж, тайлангаж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, бүртгэлийн мэргэжилтэн /С.Мөнх-Очир/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД



02 D/Tush-A/71-Da